



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар Д/300

Хэрлэн сум

“Улаанбаатар травел экспо 2023” аялал
жуулчлалын үзэсгэлэнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, олон улсад сурталчлах, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын Мишээл экспод 2023 оны 5 дугаар сарын 19-өөс 2023 оны 5 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Улаанбаатар травел экспо 2023” үзэсгэлэнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцох аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, үзэсгэлэнгийн талбайн түрээсийн төлбөрт 1,426,000 (нэг сая дөрвөн зуун хорин зургаан мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

4. Үзэсгэлэнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудыг оролцуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, аймаг орон нутгаа сурталчлан ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Мөнх-эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 18-ны өдрийн
0300 дугаар захирамжийн хавсралт

“Улаанбаатар травэл экспо 2023” үзэсгэлэнд
оролцох төсвийн тооцоо

№	Оролцох байгууллага	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж дүн	Нийт дүн
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	м2	10	100 000	1 000 000
2	Томилолт	Хүн/өдөр	1*3	142 000	426 000
	Нийт дүн				1 426 000